

2020 оны 01 сарын 27-ны өдөр

№ 21/2020

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай:

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, “Түмэн шувуут” Хувьцаат компанийн дүрмийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэг, Түмэн шувуут ХХКомпанийн Ногдол ашгийн бодлогын 3 дахь заалтыг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Түмэн шувуут” ХХКомпаний 2019 оны цэвэр ашгийн 30 хувийг мөнгөн хэлбэрээр Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилахаар тогтоосугай.

2. Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг холбогдох хууль, журамд нийцүүлэн хуваарилахыг гүйцэтгэх захирал /Ж.Болд/ болон ерөнхий нягтлан бодогч /Н.Должинсүрэн/ нарт зөвшөөрсүгэй.

3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.

4. Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирал /Ж.Болд/-т үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН

ДАРГА



Л.ЭРХЭМБАЯР